



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 5/01

Өмнөдэлгэр сум

Дотоод хяналтын ажилтнаар
ажиллуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Соёлын төвийн бүжгийн багш Н.Ганганмөрөн-г дотоод хяналтын ажилтнаар 2025 оны 01 дугаар сарын 08 ны өдрөөс ажиллуулсугай.

2.Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд удирдамж, төлөвлөгөө гарган байгууллагын хэмжээнд чанартай зохион байгуулан тайлагнаж ажиллахыг дотоод хяналтын ажилтан (Н.Ганганмөрөн)-д үүрэг болгосугай.

3.Дээрх тушаал гарсантай холбогдуулан Соёлын төвийн даргын 2024 оны Б\02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ШИНЭТУЯА

